

ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Чойбалсан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: ДОО-2025/008/НА-СТА-ТТЗ**

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Чойбалсан хот  
**2025 он**

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
Тэргүүлэх аудитор: Б.Болортуул  
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn  
Аудитын менежер: И.Сэмжидмаа  
Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn  
Ахлах аудитор: Д.Нармандах  
Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn  
Аудитор: Ч.Удвалноров  
Утас: 7058-4207, Цахим хаяг: udvalnorovch@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **АГУУЛГА**

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....	3
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5
3. Аудитын илрүүлэлт .....	7-8
4. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....	9-10

### **Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000  
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2025.03.24 № 423

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ЧОЙБАЛСАН СУМЫН  
ЗАСАГ ДАРГА Г.ТӨРБОЛД  
ТАНАА

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Чойбалсан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Үндсэн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

#### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

011022203

### Бусад асуудлын хэсэг

Тус сум нь 2024 оныг “Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах” зорилтот жилийн хөгжлийн төлөвлөгөөний хүрээнд нийт 10 бүлгийн 59 арга хэмжээ хэрэгжүүлэн ажилласан. Сумын ИТХ-ын 2024 оны 13 дугаар тогтоолоор 10.6 хувиар үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлднэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>701,773.7</b>	<b>1,616,753.8</b>
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	162,367.3	974,092.7
33	<b>АВЛАГА</b>	194,003.5	124,817.5
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	345,402.8	517,843.7
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>4,446,384.4</b>	<b>4,575,068.6</b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	4,446,384.4	4,575,068.6
39200	Биет хөрөнгө	2,377,061.2	2,504,345.4
39300	Биет бус хөрөнгө	2,069,323.2	2,070,723.2
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>5,148,158.0</b>	<b>6,191,822.4</b>
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>15,321.7</b>	<b>19,389.7</b>
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	15,321.7	19,389.7
41300	Өглөг	15,321.7	19,389.7
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>5,132,836.3</b>	<b>6,172,432.8</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	5,132,836.3	6,172,432.8
51100	Засгийн газрын оруулсан капитал	2,489,431.5	2,489,431.5
51200	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	2,528,969.1	3,568,565.5
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	114,435.8	114,435.8
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>5,148,158.0</b>	<b>6,191,822.4</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,796,437.9</b>	<b>3,204,304.0</b>
11	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>701,556.4</b>	<b>779,886.4</b>
110	Орлогын албан татвар	216,436.7	430,112.8
1100	Хувь хүний орлогын албан татвар	226,425.8	463,258.0
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(9,989.10)	(33,145.20)
113	Хөрөнгийн албан татвар	133,314.7	49,821.8
118	Бусад татвар, төлбөр, хураамж	351,805.0	299,951.7
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	1,185,174.4	616,597.8
120	Нийтлэг татварын бус орлого	1,185,174.4	586,652.8
122	Тусламжийн орлого	0.0	29,945.0
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,909,707.1</b>	<b>1,807,819.7</b>
II	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,152,483.7</b>	<b>1,549,305.8</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,152,483.7</b>	<b>1,549,305.8</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,002,479.3</b>	<b>1,494,511.4</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	481,046.0	760,325.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60,045.5	88,480.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогмол зардал	22,459.4	102,702.4
2104	Хангамж, бараа материалын зардал	66,143.5	76,374.4
2105	Нормативт зардал	1,506.9	11,751.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,931.0	12,783.5
2107	Томилолт, зочны зардал	12,128.0	27,460.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	101,288.1	22,994.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	247,931.0	391,638.8
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,150,004.4</b>	<b>54,794.4</b>
III	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>1,643,954.2</b>	<b>1,654,998.1</b>
IV	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
V	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,172,584.7</b>	<b>619,580.5</b>
VI	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>471,369.5</b>	<b>1,035,417.7</b>

Чойбалсан сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>2,633,346.2</b>	<b>2,633,346.2</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	24,432.7	24,432.7
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,657,778.9	2,657,778.9
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-14,127.3	-14,127.3
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	2,017,815.2	2,017,815.2
9	Тайлант үеийн үр дүн	471,369.5	471,369.5
10	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>5,132,836.3</b>	<b>5,132,836.3</b>
11	<b>2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>5,132,836.3</b>	<b>5,132,836.3</b>
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	4,178.8	4,178.8
13	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>5,137,015.1</b>	<b>5,137,015.1</b>
19	Тайлант үеийн үр дүн	1,035,417.7	1,035,417.7
20	<b>2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл</b>	<b>6,172,432.8</b>	<b>6,172,432.8</b>

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,662,376.7</b>	<b>2,692,223.0</b>
11	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>701,556.4</b>	<b>779,886.4</b>
110	Орлогын албан татвар	216,436.7	430,112.8
1100	Хувь хүний орлогын албан татвар	226,425.8	463,258.0
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(9,989.10)	(33,145.20)
113	Хөрөнгийн албан татвар	133,314.7	49,821.8
118	Бусад татвар, төлбөр, хураамж	351,805.0	299,951.7
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	5,024.7	1,288.6
1181	Газрын төлбөр	346,780.3	298,663.0
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>51,113.3</b>	<b>104,516.9</b>
120	Нийтлэг татварын бус орлого	51,113.3	89,516.9
122	Тусламжийн орлого	0.0	15,000.0
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,909,707.1</b>	<b>1,807,819.7</b>
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,954,879.1</b>	<b>1,236,244.0</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,954,879.1</b>	<b>1,236,244.0</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>804,874.6</b>	<b>1,181,449.5</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	487,717.9	755,067.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60,045.5	88,480.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,459.4	124,363.2
2104	Хангамж, бараа материалын зардал	31,266.7	26,557.8
2105	Нормативт зардал	1,004.0	1,274.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,000.0	21,394.3
2107	Томилолт, зочны зардал	12,128.0	27,460.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	101,288.1	4,354.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	78,965.1	132,497.1
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,150,004.4</b>	<b>54,794.4</b>
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>707,497.7</b>	<b>1,455,979.0</b>
<b>IV</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>980,921.2</b>	<b>644,253.7</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>980,921.2</b>	<b>644,253.7</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	980,921.2	644,253.7
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(980,921.20)</b>	<b>(644,253.70)</b>
<b>VII</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	<b>(130,000.00)</b>	<b>0.0</b>
23	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>130,000.0</b>	<b>0.0</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>(403,423.50)</b>	<b>811,725.3</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	565,790.9	162,367.3
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	162,367.3	974,092.7

Чойбалсан сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,492,670.5</b>	<b>1,775,211.3</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,243,307.8</b>	<b>1,139,380.5</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,175,570.7</b>	<b>1,084,586.0</b>
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	778,253.3	755,067.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	96,867.6	88,480.5
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	136,654.7	124,363.2
Хангамж, бараа материалын зардал	27,568.2	26,557.8
Нормативт зардал	1,401.4	1,274.4
Эд хогшил, урсгал засварын зардал	30,478.4	29,817.1
Томилолт, зочны зардал	28,111.3	27,460.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,555.4	4,354.7
Бараа үйлчилгээний бусад зардал	70,680.4	27,210.8
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>67,737.1</b>	<b>54,794.4</b>
Бусад урсгал шилжүүлэг	67,737.1	54,794.4
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,249,362.7</b>	<b>635,830.8</b>
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,492,670.5</b>	<b>2,382,180.9</b>
<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>2,420,233.1</b>	<b>2,290,919.0</b>
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>48,437.4</b>	<b>76,261.9</b>
<b>ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ</b>	<b>24,000.0</b>	<b>15,000.0</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	96,001.2
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	702,970.7
<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	-	-
<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	-	-
<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	-	-
<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	-	-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	105,286.3
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	105,286.3
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	105,286.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	105,286.3
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	105,286.3
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	105,286.3
<b>III</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 436.0 сая төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрсэнд 10.6 сая төгрөгийн 1 албан шаардлага, 425.4 сая төгрөгийн 4 зөвлөмж хүргүүлсэн.

3.1 Албан шаардлага

ОНХС-ийн Санхүүгийн тайланд тусгагдсан өглөг, авлагын 10.6 сая төгрөгийн үлдэгдэл тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

### 3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Төсвийн орлого бүрдүүлэлттэй холбоотой

**Илрүүлэлт:** Тайлант оны сумын төсвийн орлогын төлөвлөгөө нийт дүнгээр давж биелсэн ч түгээмэл тархацтай АМНАТ-ийн төлөвлөгөө 15.0 сая төгрөг буюу 100 хувиар, галт зэвсгийн албан татварын төлөвлөгөө 0.2 сая төгрөг буюу 8.4 хувиар, улсын тэмдэгтийн хураамж 0.7 сая төгрөг буюу 35.6 хувиар тус тус тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Төсвийн орлогыг бодитой төлөвлөж, бүрэн төвлөрүүлэх.

#### 2. ОНХС-ийн хөрөнгөөр хийхээр төлөвлөсөн ажлын гүйцэтгэлтэй холбоотой

**Илрүүлэлт:** ОНХС-ийн хөрөнгөөр хийхээр төлөвлөсөн ажлуудын санхүүжилт 66.3 хувийн гүйцэтгэлтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ", 41.2.7-д "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** ОНХС-ийн хөрөнгөөр хийхээр төлөвлөсөн ажлын хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах.

#### 3. Сумын хөгжлийн төлөвлөгөөний биелэлт, гүйцэтгэлтэй холбоотой

**Илрүүлэлт:** Тус сум нь 2024 оныг "Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах" зорилтот жилийн хөгжлийн төлөвлөгөөний хүрээнд нийт 10 бүлгийн 59 арга хэмжээ хэрэгжүүлэн ажилласан. Сумын ИТХ-ын 2024 оны 13 дугаар тогтоолоор 10.6 хувиар үнэлсэн байна.

**Өгсөн зөвлөмж:** Сумын хөгжлийн төлөвлөгөөний биелэлтийг бүрэн гүйцэтгэлтэй хангаж ажиллах.

#### 4. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой

**Илрүүлэлт:** Шилэн дансны цахим хуудаст оруулбал зохих 179 мэдээллээс 11 мэдээллийн хугацааг хоцроосон байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн дагуу цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулахтай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Шилэн дансны цахим хуудаст оруулах мэдээллийг хуулийн хугацаанд ил тод мэдээлж байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасныг хэрэгжүүлж ажиллах. Зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 6 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Чойбалсан сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл												
Зөрчлийн утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ОНХС-ийн Санхүүгийн тайланд тусгагдсан өглөг, авлагын үлдэгдэл тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй	1	10.6			1	10.6						
Тайлант оны сумын төсвийн орлогын төлөвлөгөө нийт дүнгээр давж биелсэн ч түгээмэл тархацтай АМНАТ-ын төлөвлөгөө 15.0 сая төгрөг буюу 100 хувиар, галт зэвсгийн албан татварын төлөвлөгөө 0.2 сая төгрөг буюу 8.4 хувиар, улсын тэмдэгтийн хураамж 0.7 сая төгрөг буюу 35.6 хувиар тус тус тасарсан.	1	15.9					1	15.9				
ОНХС-ийн хөрөнгөөр хийхээр төлөвлөсөн ажлуудын санхүүжилт 66.3 хувийн гүйцэтгэлтэй.	1	409.5					1	409.5				
Тус сум нь 2024 оныг "Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах" зорилтот жилийн хөгжлийн төлөвлөгөөний хүрээнд нийт 10 бүлгийн 59 арга хэмжээ хэрэгжүүлэн ажилласан. Сумын ИТХ-ын 2024 оны 13 дугаар тогтоолоор 10.6 хувиар үнэлсэн.	1	-					1	-				
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>436.0</b>			<b>1</b>	<b>10.6</b>	<b>3</b>	<b>425.4</b>				

Чойбалсан сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудаст оруулбал зохих 179 мэдээллээс 11 мэдээллийн хугацааг хоцроосон.	1	-	-	-	-	-	1	-
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>